



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,
Утас: 51-263051, Факс: (976) 7004-3479
E-mail: info@energy.gov.mn

2022. 10. 25 № 8/4075

танай _____ -ны № _____ -т

Үүрэг даалгавар хүргүүлэх тухай

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН
ҮЙЛДВЭР, КОМПАНИУДЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ НАРТ**

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн аудитад нийт 31 байгууллага хамрагдсан. Санхүүгийн тайлангийн аудитаар 30,166.3 сая төгрөгийн 91 зөвлөмж, 403.6 сая төгрөгийн 34 төлбөрийн акт, 9,035.8 сая төгрөгийн 75 албан шаардлага, хариуцлага тооцох 3,637.1 сая төгрөгийн 10 зөрчил, нийт 43,242.8 сая төгрөгийн 210 алдаа, зөрчил илэрч, 25 байгууллага зөрчилгүй, 6 байгууллага хязгаарлалттай дүгнэлттэй гарсан.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.6.3. "дотоод аудитын нэгж нь холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц", 7.6.4."хөндлөнгийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явц"-ыг Төсвийн өрөнхийлөн захирагч болон Дотоод аудитын хороонд хариуцан тайлагнана гэж заасны дагуу Төсвийн өрөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг гаргасан.

2022 оны гуравдугаар улирлын байдлаар аудитын зөвлөмж 83.3%, акт 90.0%, албан шаардлага 79.2% хэрэгжиж, нэгдсэн дүнгээр 84.2%-ийн биелэлттэй байна. Үүнд: 91 зөвлөмж өгөгдсөнөөс 50 зөвлөмж 100 хувь хэрэгжсэн, хэрэгжих шатандаа 36 зөвлөмж, хэрэгжилт хангалтгүй 5 зөвлөмж байна. 34 төлбөрийн акт ногдуулснаас 31 актын хэрэгжилтийг 100 хувь хангасан бөгөөд 1.3 сая төгрөгийн 3 актын хэрэгжилт хангагдаагүй байна. 75 албан шаардлагаас 33 албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж, 32 албан шаардлагыг хэрэгжүүлэх шатандаа, 10 албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй дүнтэй гарсан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 42.1."Хүчин төгөлдөр болсон албан шаардлага, актыг хугацаанд нь биелүүлээгүй ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасан тул байгууллагын гүйцэтгэх удирдлагууд санхүүгийн тайлангийн жилд багтаан төрийн аудитын байгууллагын зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор гүйцэтгэл ирүүлэхийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Н.ТАВИНБЭХ



170604092

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК

Зөвлөмжийн хэрэгжилт:

№	Өгсөн зөвлөмж	Дүн /мян.төг/	Байгууллагаас ирсэн биелэлт	Үнэлгээ
1	"АДС" ТӨХК нь 2021 оны 9 дүгээр сард хуучин граж болох 358.9м2 талбайг засварлаж цайны газрын үйл ажиллагаа эрхлэгчид түрээслүүлсэн байна. Засварласан цайны газрын үйлчилгээний заал нь 172.86м2 байхад ТӨБЗГ-т мэдэгдэж, түрээсийн гарээнд өөрчлөлт оруулаагүй байна.	4,030.9	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлж цайны газар зайлшгүй ажиллах шаардлагатай болсон тул 2022.09.15-ны өдөр Бэмбөөжиг ХХК-тай цайны газрыг түрээслүүлэх, түрээслэх гэрээг байгуулан ажиллаж байна. Ингэхдээ цайны газрын нийт талбайгаас ажилнуудын хооллож буй заалны хэмжээг хасах 330м2-д түрээс тооцохоор гэрээнд тусгасан. Гэрээг ТӨБЗГ-т хургуулсан, батлагдаж ирээгүй байна.	70%
2	Нийслэлийн татварын газрын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн НА-22210000053 дугаар "Нөхөн ногдуулалтын акт"-н дагуу 20,801.6 мянган төгрөг, "Дулааны эрчим хүч үйлдвэрлэх" тусгай зөвшөөрлийг хуульд заасан хугацаанд сунгуулаагүйгээс 1,000.0 мянган төгрөг, үнс тээврэлдэг том оврын машины төв замын зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй тээвэр хийсний 349.8 мянган төгрөг, нийт 22,151.4 мянган төгрөгийн торгууль төлсөн байна.	22,151.4	Нийслэлийн татварын газрын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн НА-22210000053 дугаар "Нөхөн ногдуулалтын акт"-аар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, давтан гаргахгүй байхад анхаарч, татварын тайлан болон бусад тайлан мэдээг хуулийн хугацаанд хүргүүлж ажиллаж байна.	70%
3	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй програмчлагдах логик контроллёртой холбоотой 7 хөрөнгөнөөс 5 эвдэрсэн ашиглах боломжгүй агуулахад, 2 нь шинээрээ буюу нөөцөнд байгаа хөрөнгөнд нийт 13,059.6 мянган төгрөгийн элэгдэл тооцож байгууллагын үр дүнг бууруулсан байна.	13,059.6	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй програмчлагдах логик 2 шинэ контроллёрын элэгдлийн зардлыг запруулж, нөөцөнд бүртгэсэн. Мөн НБББББ-ийн тусгай бодлогыг Гүйцэтгэх захирлын 2022.09.15-ны өдрийн А/115 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд тус бодлогод ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэх өртөгтэй ашиглахгүй байгаа хөрөнгийн элэгдлийн зардлыг хэрхэн тооцох талаар тусгасан болно.	100%
4	Анхан шатны баримтаар баталгаажсан боловч Цахим төлбөрийн баримтаар /И-баримт/ баталгаажаагүй 26,467.3 мянган төгрөгийн гүйлгээ байна.	26,467.3	Анхан шатны баримтын бүрдлийн хамт и-баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаж байна.	100%
5	Санхүү бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөөгүй байна. Мөрдөхөөр батлагдсан НБББББ-г мөрдэж, хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Батлагдсан НБББББ-т холбогдох дүрэм, журам, заавар, зарчим болон практикт тохиолдсон үйл явдлуудыг хэрхэн бүртгэх талаар нэмэлтээр тусгаж, гарын авлагыг журмуудыг боловсруулах зарчмаар зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд Гүйцэтгэх захирлын А/56, А/84 тоот тушаалуудаар Кассын үйл ажиллагааны журам, Цалингийн журмыг батлуулан мөрдэж ажиллаж байна. Мөн НБББББ-ийн тусгай бодлогыг Гүйцэтгэх захирлын А/115 дугаар тушаалаар батлуулан санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.	100%
	ДҮН	65,709.2		88%

Албан шаардлагын хэрэгжилт:

№	Алдаа, зөрчил			Барагдуулах эцсийн хугацаа	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
	Утга	Албан шаардлагын огноо, дугаар	Дүн /мян.төг/			
1	"Дулааны эрчим хүч түгзэх" үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр "Нахын баян констракшн" ХХК, "Монгол ташуур констракшн" ХХК, УБТЗ ХНН-н ЗЗМС зэрэг байгууллагуудад дулааны эрчим хүч түгзэх үйл ажиллагаа явуулж орлого олсон.	2022.03.15 №434/A0150055 АХГ-2022/109/НА-СА-ТӨА	15,568.74	2022.09.30	Дулааны эрчим хүч түгзэх тусгай зөвшөөрлийн талаар Эрчим хүчний зохицуулах хороонд хандсан боловч 20.0 мянган Гкал дулааны эрчим хүч түгзэх тохиолдолд тусгай зөвшөөрөл олгодог тул өөрийн түгээлтийн 3 байгууллагад цаашид дулааны эрчим хүчээр хангах боломжгүй талаар 2022.03.04-ний өдөр мэдэгдэл өгч, техникийн арга хэмжээ авч ажиллах тухай 01-03/126, 127 албан тоот тус тус хүргүүлсэн бөгөөд дулааны эрчим хүчээр хангаж ажиллаагүй болно.	100%

2	<p>Тайлант онд хурал зохион байгуулахад 2,904.7 мянган төгрөг зарцуулсан байна. "Нью аженси" ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан 99/2021 дугаар www.news.mn сайтаар дамжуулан эрчим хүчин талаарх мэдээ, мэдээллийг түгээх ажил гүйцэтгэх гэрээний дагуу 4,950.0 мянган төгрөг, "Дүгнэх цэг" нэвтрүүлэгтэй холбоотойгоор МҮОНРТ-н 1,200.0 мянган төгрөг, Зөв зүг студид 2,800.0 мянган төгрөг, нийт 8,950.0 мянган төгрөгийн нэвтрүүлгийн төлбөр төлсэн байна. Тайлант онд шагнал, урамшууланд 38,815.9 мянган төгрөг зарцуулсан байна.</p>	2022.03.15 №435/A0150055 АХГ-2022/109/НА-СА-ТӨА	50,670.6	2022.09.30	<p>Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2022 онд телевизийн нэвтрүүлэг болон мэдээ, мэдээлэл түгээх, зар сурталчилгааны чиглэлээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулах болон үүнтэй холбоотой төлбөр төлөгдөөгүй болно.</p> <p>Тайлант хугацаанд шагнал, урамшуулалт олгоогүй.</p>	100%
3	<p>Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дун бүхий 5 орлогын гүйлгээний 104,835.1 мянган төгрөг, зарлагын 3 гүйлгээний 60,134.2 мянган төгрөгийн гүйлгээ нийт 164,969.3 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.</p>	2022.03.15 №436/A0150055 АХГ-2022/109/НА-СА-ТӨА	164,969.4	2022.09.30	<p>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим хуудсанд байршуулах бүх мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж ажиллаж байна. Мөн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг сайжруулах Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/90 дугаар тушаалаар Шилэн дансны цахим хуудасны мэдээллийг бэлтгэх, байршуулах албан тушаалтнуудын жагсаалтыг шинэчлэн батлан, мөрдөж ажиллаж байна.</p>	91.3%
	ДҮН		231,208.7			97.1%
	ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ					92.5%

**Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмж, акт,
албан шаардлагын биелэлт**

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Аудитын санал, дүгнэлт	2022-09-30-ны байдлаарх биелэлт			
			Биелэлтийн дундаж	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага
1	"ДЦС-2" ТӨХК	Зөрчилгүй	100.0%	100.0%		
2	"ДоБЭХС" ТӨХК	Зөрчилгүй	100.0%			100.0%
3	"ДҮТ" ТӨХХК	Зөрчилгүй	100.0%	100%	100%	100%
4	"УГДХС" ТӨХК	Зөрчилгүй	100.0%			
5	"ДДС" ТӨХК	Зөрчилгүй	99.7%	99.0%	100%	100.0%
6	"ӨБЦТС" ТӨХК	Зөрчилгүй	97.6%	92.7%	100%	100.0%
7	"ДЦС-4" ТӨХК	Зөрчилгүй	96.7%	100.0%	100%	90.0%
8	"ДадЦС" ТӨХК	Хязгаарлалттай	96.3%	100%		92.5%
9	"ЭДЦС" ТӨХК	Зөрчилгүй	95.9%	87.7%	100%	100.0%
10	"АУЭХС" ТӨХК	Зөрчилгүй	95.0%	100.0%	100%	85.0%
11	"ДЦС-3" ТӨХК	Зөрчилгүй	94.5%	93.6%	100%	90%
12	"УБДуС" ТӨХК	Зөрчилгүй	93.7%	81.0%	100%	100.0%
13	"Амгалан ДС" ТӨХК	Зөрчилгүй	92.5%	88.0%		97.0%
14	"ББЭХС ТӨХК" ТӨХК	Зөрчилгүй	91.3%	100.0%	100%	73.8%
15	"Дулаан ШГ" ТӨХК	Зөрчилгүй	90.7%		100%	81.4%
16	"Ховдын ДС" ТӨХК	Зөрчилгүй	90.0%	90.0%		
17	ТТДЦС ТӨХХК	Хязгаарлалттай	89.4%	88%	100%	80%
18	"ЦДУС" ТӨХК	Зөрчилгүй	87.7%	91.0%	100%	72.0%
19	ЭХЭЗХ ТӨААТҮГ	Хязгаарлалттай	85.8%	90%		81.6%
20	Налайхын ДС ТӨХК	Зөрчилгүй	84.7%	87.5%	100%	66.7%
21	"ЭБЦТС" ТӨХК	Зөрчилгүй	84.4%	85.0%	100%	68.3%
22	ЭГУЦС ТӨХХК	Хязгаарлалттай	80.0%	80%		
23	"ДзДЦС" ТӨХК	Зөрчилгүй	79.6%	50.0%	100%	88.9%
24	"Багануурын ДС" ТӨХК	Зөрчилгүй	75.8%	75%		76.6%
25	"СЭХҮТ" ТӨААТҮГ	Хязгаарлалттай	71.5%	73%		70%
26	"БЗӨБЦТС" ТӨХК	Зөрчилгүй	67.5%	50.0%		85.0%
27	"УБЦТС" ТӨХК	Хязгаарлалттай	63.1%	71.4%	60%	58.0%
28	"ЭХХТ" ТӨААТҮГ	Зөрчилгүй	61.7%		67%	57%
29	"Хөвсгөл ДС" ТӨХК	Зөрчилгүй	38.4%	66.7%		10.0%
	ДУНДАЖ ХУВЬ		84.2%	83.3%	90.0%	79.2%

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР